



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Чингэлтэй дүүргийн Нийтлэг үйлчилгээний газар ОНӨТҮГ-ын 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

**Аудитын код:** НТАГ-2025/072/НА-СТА-ОНӨҮГ

Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Улаанбаатар хот 2025 он	Нийслэл дэх Төрийн аудитын газрын дэд дарга	Ч.Болд
	Утас: 7000-7734	Цахим хаяг: boldch@audit.gov.mn
	Санхүү-нийцлийн аудитын хэлтсийн дарга	Х.Түвшинбаяр
	Утас: 315558	Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn
	Аудитын менежер	Я.Алтанцэцэг
	Утас: 325093	Цахим хаяг: altantsetsegya@audit.gov.mn
Ахлах аудитор:	Н:Баттоого	
Утас: 325093	Цахим хаяг: battogoon@audit.gov.mn	
Аудитор:	Р.Баярмаа	
Утас: 325093	Цахим хаяг: bayarmaar@audit.gov.mn	

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
НИЙСЛЭЛ ДЭХ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,  
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,  
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54  
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2025. 03. 14 № 01/329  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН  
НИЙТЛЭГ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ  
ГАЗАР ОНӨТҮГ-ЫН ДАРГЫН  
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ Ш.МӨНХ-ОРГИЛ  
ТАНАА

### Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Чингэлтэй дүүргийн Нийтлэг үйлчилгээний газар ОНӨТҮГ-ын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

### Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн 1,230.91 сая төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн холбогдох заалтуудтай нийцээгүй, санхүүгийн тайлагналын эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

### Асуудлыг онцолсон тэмдэглэсэн хэсэг

Чингэлтэй дүүргээс хэрэгжүүлж буй "Ногоон бүс" телехяналтын камерын төслийн хүрээнд бүх хороодыг бүрэн камержуулсан байна. Мөн хороодын байруудад ус, гал, халдлагын аюулгүйн дохиоллын систем суулгаснаар харуул хамгаалалтын зардлын жилийн төсөвт 169.4 сая төгрөгийн хэмнэлт гарсан байна.

Байгууллага нь үйл ажиллагаандаа Олон улсын Чанарын менежмент тогтолцооны ISO 9001:2015 стандартыг 2023 оны 01 дүгээр сараас нэвтрүүлэн ажиллаж байгаа бөгөөд 2024 онд магадлан баталгаажуулалтын аудит хийлгэж гэрчилгээгээ гардан авсан байна.

### Аудитын гол асуудал

C:\Users\zandime.d\Desktop\2025\W\W01\San\_hingeltai\_2024\_03\_16\OAO\_NU00004

Төсөвт үйлдвэрийн газар нь худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, гэрээ болон гүйцэтгэлийн тайланг tender.gov.mn болон шилэн дансны системд ил тодоор мэдээлэл байршуулаагүй, тайлант оны худалдан авалтын захиалга хүсэлт өгөөгүй цахим дэлгүүрээс худалдан авалт хийгээгүй байна.

#### **Бусад асуудлын хэсэг**

Байгууллагын 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд 5 зорилтын хүрээнд 22 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөж, 93.4 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

#### **Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн хүлээх үүрэг, хариуцлага**

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, СТОУС-ын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР



М.ЭРДЭНЭЖАРГАЛ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>634,080,506.32</u></b>	<b><u>791,261,850.15</u></b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	189,108.04	-
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	189,108.04	-
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	633,891,398.28	791,261,850.15
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	391,139,796.78	245,281,380.02
35110	Тусгай зориулалттай материал	391,139,796.78	245,281,380.02
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	242,751,601.50	545,980,470.13
35410	Бичиг хэргийн материал	2,768,770.00	6,718,756.00
35420	Аж ахуйн материал	18,798,473.75	22,985,640.00
35430	Сэлбэг хэрэгсэл	14,163,550.00	30,710,025.00
35440	Түлш, шатах тослох материал	724,026.30	3,691,253.28
35450	Барилгын засварын материал	97,798,942.45	365,062,656.85
35470	Бусад хангамжийн материал	108,497,839.00	116,812,139.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>3,428,873,878.55</u></b>	<b><u>5,615,954,680.18</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	3,428,873,878.55	5,615,954,680.18
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	3,121,476,278.48	4,756,808,603.74
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,324,853,161.00	1,711,404,286.62
39202	Хуримтлагдсан элэгдэл	(3,503,074.79)	(184,588,788.57)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	108,473,208.00	108,473,208.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(73,153,836.40)	(91,822,677.08)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	1,767,663,569.54	3,912,312,684.33
39206	Хуримтлагдсан элэгдэл	(130,124,778.39)	(812,688,606.40)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	59,409,060.00	61,361,560.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(19,387,026.00)	(38,195,059.20)
39214	Бусад үндсэн хөрөнгө	96,939,995.00	109,939,995.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(9,693,999.48)	(19,387,998.96)
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	307,397,600.07	859,146,076.44
39301	Програм хангамж	308,562,600.00	906,591,020.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,164,999.93)	(47,444,943.56)
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>4,062,954,384.87</u></b>	<b><u>6,407,216,530.33</u></b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b><u>12,405,734.56</u></b>	<b><u>37,803,200.00</u></b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	12,405,734.56	37,803,200.00
<b>413</b>	<b>Өглөг</b>	12,405,734.56	37,803,200.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	2,907,186.00	-
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	9,498,548.56	37,803,200.00
41361	Байгууллагад төлөх өглөг	9,498,548.56	37,803,200.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>4,050,548,650.31</u></b>	<b><u>6,369,413,330.33</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	4,050,548,650.31	6,369,413,330.33
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	4,050,548,650.31	6,369,413,330.33
51210	Өмнөх үеийн үр дүн	570,826,819.72	4,050,548,650.31
51220	Тайлант үеийн үр дүн	3,479,721,830.59	2,318,864,680.02
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>4,062,954,384.87</u></b>	<b><u>6,407,216,530.33</u></b>

## 2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>6,496,261,731.34</b>	<b>7,173,386,126.88</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>3,415,867,502.88</b>	<b>2,392,603,189.17</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	3,415,867,502.88	2,392,603,189.17
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	3,415,867,502.88	2,392,603,189.17
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	630,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	875,000.00	-
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	3,414,992,502.88	2,391,973,189.17
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>3,080,394,228.46</b>	<b>4,780,782,937.71</b>
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	3,080,394,228.46	4,780,782,937.71
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	3,080,394,228.46	4,780,782,937.71
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>2,939,623,767.75</b>	<b>4,502,459,350.08</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>2,939,623,767.75</b>	<b>4,502,459,350.08</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	2,930,663,767.75	4,478,879,350.08
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	601,891,675.56	953,183,607.22
210101	Үндсэн цалин	322,192,769.50	465,006,922.40
210102	Нэмэгдэл	79,632,275.07	129,805,406.53
210103	Унаа хоолны хөнгөлөлт	148,054,534.15	235,598,458.13
210104	Урамшуулал	40,683,475.90	102,174,520.16
210105	Гэрээт ажлын хөлс	11,328,620.94	20,598,300.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	74,113,400.00	115,802,136.92
210201	Тэтгэврийн даатгал	51,080,128.88	79,470,245.39
210202	Тэтгэмжийн даатгал	6,107,649.60	9,595,988.95
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,793,719.36	5,442,979.89
210204	Ажилгүйдлийн даатгал	1,082,099.80	4,196,264.96
210205	Эрүүл мэндийн даатгал	11,049,802.36	17,096,657.73
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	585,136,269.58	623,046,600.00
210301	Гэрэл, цахилгаан	383,962,272.60	423,676,356.46
210302	Түлш, халаалт	130,308,366.31	130,645,786.32
210303	Цэвэр, бохир ус	70,865,630.67	68,724,457.22
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	99,950,438.35	96,569,732.58
210401	Бичиг хэрэг	4,694,037.00	2,642,866.00
210402	Тээвэр, шатахуун	10,888,286.10	13,756,773.02
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,219,698.00	6,254,909.81
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	17,656,400.00	16,931,200.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	63,492,017.25	56,983,983.75
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	822,974,809.57	1,410,393,888.82
210604	Урсгал засвар	822,974,809.57	1,410,393,888.82
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	548,597,537.00	397,344,313.00

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	544,297,537.00	396,969,813.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	-	238,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	-	136,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	4,300,000.00	-
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>197,999,637.69</b>	<b>882,539,071.54</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	7,100,000.00	33,997,592.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	7,800,000.00	6,890,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	183,099,637.69	841,651,479.54
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>8,960,000.00</b>	<b>23,580,000.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>8,960,000.00</b>	<b>22,950,000.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	8,960,000.00	22,950,000.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>-</b>	<b>630,000.00</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	630,000.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b><u>3,556,637,963.59</u></b>	<b><u>2,670,926,776.80</u></b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>76,916,133.00</b>	<b>352,062,096.78</b>
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	76,916,133.00	352,062,096.78
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	<b>(76,916,133.00)</b>	<b>(352,062,096.78)</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b><u>3,479,721,830.59</u></b>	<b><u>2,318,864,680.02</u></b>

### 2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	<b>2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	570,826,819.72	570,826,819.72
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-
C03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>570,826,819.72</b>	<b>570,826,819.72</b>
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-
C07	Тайлант үеийн үр дүн	3,479,721,830.59	3,479,721,830.59
C08	<b>2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>4,050,548,650.31</b>	<b>4,050,548,650.31</b>
D01	<b>2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл</b>	<b>4,050,548,650.31</b>	<b>4,050,548,650.31</b>
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-
D03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>4,050,548,650.31</b>	<b>4,050,548,650.31</b>
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	2,318,864,680.02	2,318,864,680.02
D09	<b>2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b><u>6,369,413,330.33</u></b>	<b><u>6,369,413,330.33</u></b>

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b><u>3,081,269,228.46</u></b>	<b><u>4,781,412,937.71</u></b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>875,000.00</b>	<b>630,000.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	875,000.00	630,000.00
120004	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	875,000.00	630,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	630,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	875,000.00	-
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>3,080,394,228.46</b>	<b>4,780,782,937.71</b>
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	3,080,394,228.46	4,780,782,937.71
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	3,080,394,228.46	4,780,782,937.71
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b><u>2,833,648,253.02</u></b>	<b><u>4,144,517,545.71</u></b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>2,833,648,253.02</b>	<b>4,144,517,545.71</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>2,824,688,253.02</b>	<b>4,120,937,545.71</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	598,749,000.00	955,901,685.18
210101	Үндсэн цалин	319,050,094.94	467,725,000.36
210102	Нэмэгдэл	79,632,275.07	129,805,406.53
210103	Унаа хоолны хөнгөлөлт	148,054,534.15	235,598,458.13
210104	Урамшуулал	40,683,474.90	102,174,520.16
210105	Гэрээт ажлын хөлс	11,328,620.94	20,598,300.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	74,113,400.00	115,802,136.94
210201	Тэтгэврийн даатгал	51,080,128.88	79,470,245.41
210202	Тэтгэмжийн даатгал	6,107,649.60	9,595,988.95
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,793,719.36	5,442,979.89
210204	Ажилгүйдлийн даатгал	1,082,099.80	4,196,264.96
210205	Эрүүл мэндийн даатгал	11,049,802.36	17,096,657.73
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	585,136,269.58	623,046,600.00
210301	Гэрэл, цахилгаан	383,962,272.60	423,676,356.46
210302	Түлш, халаалт	130,308,366.31	130,645,786.32
210303	Цэвэр, бохир ус	70,865,630.67	68,724,457.22
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	88,352,718.00	106,688,611.81
210401	Бичиг хэрэг	4,241,390.00	6,565,750.00
210402	Тээвэр, шатахуун	10,265,000.00	16,724,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,219,698.00	6,254,909.81
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	17,656,400.00	16,931,200.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	52,970,230.00	60,212,752.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	6,190,700.00	8,212,700.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	6,190,700.00	8,212,700.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	818,171,697.00	1,673,575,706.78
210604	Урсгал засвар	818,171,697.00	1,673,575,706.78
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	639,074,468.44	596,822,513.00

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	634,774,468.44	596,448,013.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	-	238,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	-	136,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	4,300,000.00	-
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>14,900,000.00</b>	<b>40,887,592.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	7,100,000.00	33,997,592.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	7,800,000.00	6,890,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>8,960,000.00</b>	<b>23,580,000.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>8,960,000.00</b>	<b>22,950,000.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	8,960,000.00	22,950,000.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>-</b>	<b>630,000.00</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	630,000.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b><u>247,620,975.44</u></b>	<b><u>636,895,392.00</u></b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>247,620,975.44</b>	<b>636,895,392.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>247,620,975.44</b>	<b>636,895,392.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>247,620,975.44</b>	<b>636,895,392.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	247,620,975.44	636,895,392.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b><u>(247,620,975.44)</u></b>	<b><u>(636,895,392.00)</u></b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>0.00</b>	<b>-</b>

## 2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	5,207,022,200.00	4,780,782,937.71	426,239,262.29	91.81
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	5,207,022,200.00	4,780,782,937.71	426,239,262.29	91.81
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	5,184,022,200.00	4,757,832,937.71	426,189,262.29	91.78
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	1,032,078,700.00	955,901,685.18	76,177,014.82	92.62
210101	Үндсэн цалин	508,553,300.00	467,725,000.36	40,828,299.64	91.97
210102	Нэмэгдэл	147,850,500.00	129,805,406.53	18,045,093.47	87.80
210103	Унаа хоолны хөнгөлөлт	269,319,900.00	235,598,458.13	33,721,441.87	87.48
210104	Урамшуулал	85,756,700.00	102,174,520.16	(16,417,820.16)	119.14
210105	Гэрээт ажлын хөлс	20,598,300.00	20,598,300.00	-	100.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	132,365,800.00	115,802,136.94	16,563,663.06	87.49
210201	Тэтгэврийн даатгал	91,689,100.00	79,470,245.41	12,218,854.59	86.67
210202	Тэтгэмжийн даатгал	10,563,400.00	9,595,988.95	967,411.05	90.84
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,863,400.00	5,442,979.89	1,420,420.11	79.30

Чингэлтэй дүүргийн Нийтлэг үйлчилгээний газар ОНӨТҮГ-ын 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

210204	Ажилгүйдлийн даатгал	3,818,400.00	4,196,264.96	(377,864.96)	109.90
210205	Эрүүл мэндийн даатгал	19,431,500.00	17,096,657.73	2,334,842.27	87.98
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	623,046,600.00	623,046,600.00	-	100.00
210301	Гэрэл, цахилгаан	417,252,100.00	423,676,356.46	(6,424,256.46)	101.54
210302	Түлш, халаалт	130,296,500.00	130,645,786.32	(349,286.32)	100.27
210303	Цэвэр, бохир ус	75,498,000.00	68,724,457.22	6,773,542.78	91.03
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	151,755,500.00	106,688,611.81	45,066,888.19	70.30
210401	Бичиг хэрэг	7,154,500.00	6,565,750.00	588,750.00	91.77
210402	Тээвэр, шатахуун	16,724,000.00	16,724,000.00	-	100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	6,468,000.00	6,254,909.81	213,090.19	96.71
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	18,000,000.00	16,931,200.00	1,068,800.00	94.06
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	103,409,000.00	60,212,752.00	43,196,248.00	58.23
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	8,250,000.00	8,212,700.00	37,300.00	99.55
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	8,250,000.00	8,212,700.00	37,300.00	99.55
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	2,547,243,800.00	2,292,621,098.78	254,622,701.22	90.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	558,008,500.00	566,415,621.58	(8,407,121.58)	101.51
210602	Тавилга	34,398,500.00	34,402,500.00	(4,000.00)	100.01
210604	Урсгал засвар	1,954,836,800.00	1,691,802,977.20	263,033,822.80	86.54
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	648,381,800.00	614,672,513.00	33,709,287.00	94.80
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	647,518,700.00	614,298,013.00	33,220,687.00	94.87
210803	Даатгалын үйлчилгээ	320,000.00		320,000.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	243,100.00	238,500.00	4,600.00	98.11
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	300,000.00	136,000.00	164,000.00	45.33
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	40,900,000.00	40,887,592.00	12,408.00	99.97
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	34,000,000.00	33,997,592.00	2,408.00	99.99
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,900,000.00	6,890,000.00	10,000.00	99.86
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	23,000,000.00	22,950,000.00	50,000.00	99.78
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	23,000,000.00	22,950,000.00	50,000.00	99.78
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	23,000,000.00	22,950,000.00	50,000.00	99.78
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	5,207,022,200.00	4,781,412,937.71	425,609,262.29	91.83
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	5,207,022,200.00	4,780,782,937.71	426,239,262.29	91.81
132001	Орон нутгийн төсвөөс	5,207,022,200.00	4,780,782,937.71	426,239,262.29	91.81
<b>120004</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	-	630,000.00	(630,000.00)	-
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	630,000.00	(630,000.00)	-
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	1.00	1.00	-	100.00
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00	-	100.00

<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	49.00	41.00	8.00	83.67
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	-	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	8.00	8.00	-	100.00
620003	Үйлчлэх ажилтан	38.00	30.00	8.00	78.95
620004	Гэрээт ажилтан	2.00	2.00	-	100.00

### 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 1,230,911.3 мянган төгрөгийн зөрчил<sup>1</sup> илэрч алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх 971,233.2 мянган төгрөгийн 2 албан шаардлага, 259,678.1 мянган төгрөгийн 2 зөвлөмж өглөө.

Нийт илрүүлсэн 1,230,911.3 мянган төгрөгийн залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 1,186,816.9 мянган төгрөгөөр илүү тул “Хязгаарлалттай” дүгнэлт өглөө.

### 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

#### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Төсвийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авахдаа холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлээгүй, ажлын үр дүнг үнэлж тайлагнасан нотлох баримт хангалтгүй байна.	1	886,122.9			1	886,122.9						
Үйл ажиллагааны чиглэл өөр байгууллагуудаас бараа, ажил үйлчилгээ худалдан авсан.	1	85,110.3			1	85,110.3						
Сургууль, цэцэрлэг, ахмадын байрны засварын ажлын гүйцэтгэлийн тооцоог тухайн байгууллагатай хийж, хөрөнгө хүлээлцсэн акт үйлдээгүй, тус байгууллагууд нь санхүүгийн тайлан бүртгэлд тусгаагүй.	1	244,478.1					1	244,478.1				
“Эрүүл монгол” хөтөлбөртэй давхардуулан эрүүл	1	15,200.0					1	15,200.0				

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

мэндийн үзлэг, шинжилгээний зардлыг төсвийн хөрөнгөөс гаргаж үрэлгэн зарцуулсан.											
<b>Дүн</b>	<b>4</b>	<b>1,230,911.3</b>		<b>2</b>	<b>971,233.2</b>	<b>2</b>	<b>259,678.1</b>				

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс			
			Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил						
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил						
Цахим дэлгүүрээс бараа материал, үндсэн хөрөнгийн худалдан авалт хийгээгүй байна.	1	233,296.3			1	233,296.3
Тайлан оны эцэст их хэмжээний барилгын материалын нөөц үүсгэсэн.	1	201,962.3	1	201,962.3		
Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, гэрээ болон гүйцэтгэлийн тайланг tender.gov.mn болон шилэн дансны системд ил тодоор мэдээлээгүй.	1	-			1	-
<b>Дүн</b>	<b>3</b>	<b>435,258.6</b>	<b>1</b>	<b>201,962.3</b>	<b>2</b>	<b>233,296.3</b>
<b>Нийт дүн</b>	<b>3</b>	<b>435,258.6</b>	<b>1</b>	<b>201,962.3</b>	<b>2</b>	<b>233,296.3</b>



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 03 сарын 14 өдөр

Дугаар 376/А0270227

Улаанбаатар хот

ИТАГ - 2025/072/НА-СТА-ОНӨТҮГ

**Зөрчил арилгах тухай**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Нийслэлийн Чингэлтэй дүүргийн Нийтлэг үйлчилгээний газар ОНӨТҮГ-ын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн бараа, ажил үйлчилгээ худалдан авах арга хэмжээнд ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг мөрдөөгүй, сонгон шалгаруулалт зарлалгүйгээр 886,122,900.00 (найман зуун наян зургаан сая нэг зуун хорин хоёр мянга есөн зуун) төгрөгийн шууд гэрээ байгуулж бараа, ажил, үйлчилгээ худалдан авсан ба ажлын үр дүнг үнэлээгүй, өмнөх, дараах үеийн гүйцэтгэл тайлан байхгүй зэрэг нотлох баримт хангалтгүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1-д "Улс, орон нутгийн төсөө болон захиалагчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авахад энэ хуулийг дагаж мөрдөнө", 38 дугаар зүйлийн 38.1-д "Ерөнхий гэрээний аргын хоёрдугаар үе шатанд захиалагч худалдан авах бараа, үйлчилгээний тоо хэмжээ, хүргэх газар, хуваарь бүхий захиалгын хуудсыг цахим системд илгээж, үнийн санал дуудаж цахим дэлгүүрээс худалдан авна" 10 дугаар зүйлийн 10.3-д "Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгаадагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.9-т "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомж зөрчсөн нь энэ журмын 4.2.3-т заасан нөхцөл үүсээгүй бол" заалтад заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Бараа, ажил, үйлчилгээг худалдан авахдаа холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлээгүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2025 оны 09 дүгээр сарын 30-ны дотор Нийслэл дэх Төрийн аудитын газарт ирүүлэх;

1405040144

2.Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Нийслэлийн Чингэлтэй дүүргийн Нийтлэг үйлчилгээний газар ОНӨТҮГ-ын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ш.Мөнх-Оргил, нягтлан бодогч Н.Болормаа нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨНІ:**

АУДИТОР

ХЯНАСАН:

САНХҮҮ, НИЙЦЛИЙН АУДИТЫН  
ХЭЛТСИЙН АУДИТЫН МЕНЕЖЕР

Р.БАЯРМАА

Я.АЛТАНЦЭЦЭГ



<sup>1</sup> Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 4 давхар



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 03 сарын 14 өдөр

Дугаар 377/А0270227

Улаанбаатар хот

ИТАГ - 2025/072/НА-СТА-ОНӨТҮГ

**Зөрчил арилгах тухай**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Нийслэлийн Чингэлтэй дүүргийн Нийтлэг үйлчилгээний газар ОНӨТҮГ-ын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлан оны эцэст 201,962,300.00 (хоёр зуун нэг сая есөн зуун жаран хоёр мянга гурван зуун) төгрөгийн барилгын материалын нөөц үүсгэсэн.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.6-д "нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "Хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" заалтад заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1.Бараа материалын их хэмжээний нөөц үүсгэсэн зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2025 оны 09 дүгээр сарын 30-ны дотор Нийслэл дэх Төрийн аудитын газарт ирүүлэх;

2.Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Нийслэлийн Чингэлтэй дүүргийн Нийтлэг үйлчилгээний газар ОНӨТҮГ-ын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ш.Мөнх-Оргил, нягтлан бодогч Н.Болормаа нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨНІ:**


АУДИТОР

ХЯНАСАН:

Р.БАЯРМАА

САНХҮҮ,НИЙЦЛИЙН АУДИТЫН  
ХЭЛТСИЙН АУДИТЫН МЕНЕЖЕР

Я.АЛТАНЦЭЦЭГ



1 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 4 давхар

1425040441



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 03 сарын 14 өдөр

Дугаар 278/А0270227

Улаанбаатар хот

НТАГ-2025/072/НА-СТА-ОНӨҮГ

**Зөрчил арилгах тухай**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Нийслэлийн Чингэлтэй дүүргийн Нийтлэг үйлчилгээний газар ОНӨТҮГ-ын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Үйл ажиллагааны чиглэл өөр байгууллагуудаас 85,110,300.00 (наян таван сая нэг зуун арван мянга гурван зуун) төгрөгийн бараа, ажил үйлчилгээ худалдан авсан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "үнэн зөв байх", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 24 дүгээр зүйлийн 24.4-т "Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй бол төсөөс санхүүжилт гаргахыг хориглоно" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.9-т "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомж зөрчсөн нь энэ журмын 4.2.3-т заасан нөхцөл үүсээгүй бол" заалтад заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Үйл ажиллагааны чиглэл өөр байгууллагаас бараа, ажил үйлчилгээ худалдан авсан зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2025 оны 09 дүгээр сарын 30-ны дотор Нийслэл дэх Төрийн аудитын газарт ирүүлэх;

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Нийслэлийн Чингэлтэй дүүргийн Нийтлэг үйлчилгээний газар ОНӨТҮГ-ын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ш.Мөнх-Оргил, нягтлан бодогч Н.Болормаа нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨНІ:**

АУДИТОР

ХЯНАСАН:

САНХҮҮ, НИЙЦЛИЙН АУДИТЫН  
ХЭЛТСИЙН АУДИТЫН МЕНЕЖЕР

Р.БАЯРМАА

Я.АЛТАНЦЭЦЭГ



1. Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 4 давхар

1425040439